

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2015 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i>	<i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i>	<i>Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i>
1	2	3
"1.0. Дотоод аудитын үйл ажиллагааг хангах" гэсэн зорилтын хүрээнд:		
<p>1.1. САНХҮҮГИЙН АУДИТ: 1.1.3 Нийслэлийн ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд төлөвлөгөөт аудит хийж дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлэх, 2014 оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хянах</p>	<p>А. 2015 оны аудитын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 21 байгууллагын аудитын удирдамжийг боловсруулж, Дотоод аудитын хорооны даргаар батлуулсан. Б. Аудитын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 17 байгууллагад календарчилсан төлөвлөгөөний дагуу аудитын төлөвлөлтийг хэрэгжүүлэн тус байгууллагуудын үндсэн чиг үүрэг, зорилго зорилттой танилцан, бүтэц орон тоо, мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, холбогдох хууль, эрх зүйн актыг судлан мэдээллийн сан үүсгэсэн. В. Календарчилсан төлөвлөгөөний дагуу 6 байгууллагад санхүүгийн аудит хийхээр төлөвлөснөөс гадна 2 аудитыг төлөвлөгөөт хугацаанд дуусгаж, аудитын дүгнэлт зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Г. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нийслэлийн Дотоод аудитын албан болон нийслэлийн Аудитын газрын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчлийн харьцуулсан судалгааг хийсэн ба 2014 онд аудит хийсэн 16 байгууллагын 14 байгууллагад нийслэлийн Аудитын газар "Зөрчилгүй" санал дүгнэлт, 1 байгууллагад</p>	

	“Хязгаарлалттай” санал дүгнэлт, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.	
1.2: ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ: 1.2.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээнд гүйцэтгэлийн аудит хийх 1.2.1.1 "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хэрэгжилт 1.2.1.2 "Ухаалаг Улаанбаатар" хөтөлбөрийн хэрэгжилт	А. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэрэгжилтэд 3 дугаар улиралд (9, 10 дугаар сард) аудит хийхээр төлөвлөсөн. Б. “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, аудитын тайланг дуусгавар болгосон. Аудитын ажлын баримт (3003, 3004)-ыг аудит хийгдсэн байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэж байна. /2015.06.26-ны байдлаар/ Зарим төлөвлөгөөт аудит нийслэлийн аудитын газрын аудиттай давхацсан тул 3 дугаар улиралд хийхээр төлөвлөж байна.	
1.2.3 Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дах заалтын дагуу Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтэд сэдвийн аудит хийж дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлэх 1.2.3.1 9 дүүрэг	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран нийслэлийн Засаг даргын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаагийн баталсан удирдамжаар 9 дүүргийн он дамжсан болон энэ онд эрх шилжүүлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудад шалгалт явуулж, дүнг гарган танилцуулсан.	
1.2.4 Нийслэлийн харьяа ОНӨҮГ-уудын бүтэц, зохион байгуулалтад гүйцэтгэлийн аудит хийх	Нийслэлийн харьяа орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ)-уудын статус, бүтэц, зохион байгуулалтад гүйцэтгэлийн аудит хийж дуусан, тайланг хянуулж, аудитын ажлын баримт (3003, 3004)-уудыг аудит хийгдсэн байгууллагуудад хүргэхээр бэлтгэж байна. /2015.06.26-ны байдлаар/	
1.2.5 Нийслэлийн ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөт аудит хийж дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлэх	2014 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийн илэрсэн алдаа дутагдлыг илтгэх ажлын баримт 3003-ийг зөвлөмж болгон хүргүүлсэн ба ажлын баримт 3004-өөр хариу арга хэмжээний төлөвлөгөөг авч хяналт тавьж байна.	

<p>1.2.6 Нийслэлийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн захиалгат аудит хийх</p>	<p>Захиалгат гүйцэтгэлийн аудитыг "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 2014 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Аудитын явцад илэрсэн алдаа дутагдлыг илтгэх ажлын баримт 3003-ийг зөвлөмж болгон хүргүүлсэн ба ажлын баримт 3004-өөр хариу арга хэмжээний төлөвлөгөөг авч хяналт тавин ажиллаж байна.</p>	
<p>1.3: ЧАНАРЫН ХЯНАЛТ: 1.3.1 <i>Нийслэлийн ТЕЗ-ийн багц хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хийсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн төлөвлөгөөт аудит, сэдвийн аудит, дүүргүүдийн дотоод аудитын албаны аудитын тайланд чанарын хяналт хийх, нэгдсэн тайлан гаргаж зөвлөмж боловсруулах</i></p> <p>1.3.2. <i>Албаны дотоод хяналтын систем, эрсдлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох талаар зөвлөмж өгч, хэрэгжилтийг ханган ажиллах</i></p> <p>1.3.3. <i>Хамрах хүрээний байгууллагуудын дотоод аудиторуудад сургалт, семинар зохион байгуулах</i></p> <p>1.3.4. <i>Нийслэлийн Дотоод аудитын албаны нийт аудитор, шинжээчдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох, сургалт семинар зохион байгуулах</i></p>	<ol style="list-style-type: none"> 1. Гүйцэтгэлийн аудит, санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналт хийх ажлын баримт 4001, 4003, 4004, 4005-ыг боловсруулан, ашиглах горимыг бэлтгэж холбогдох аудиторуудад хүлээлгэн өгсөн. Дүүргүүдийн дотоод аудитын албадын аудитын үйл ажиллагаанд чанарын хяналт хийхээр удирдамжийг батлуулсан. 2. Санхүүгийн аудит хийсэн 5 байгууллагын аудит, гүйцэтгэлийн аудит хийсэн 11 байгууллагын аудит тус бүрт чанарын хяналтын ажлын баримтуудыг бүрдүүлэхийг аудиторуудад зөвлөсөн. 3. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны 21 байгууллагын 22 аудитор, дотоод хяналтын мэргэжилтнүүдийг оролцуулан, “Дотоод аудит, дотоод хяналтын тухай” сэдэвт семинарыг 5 дугаар сарын 29-нд зохион байгуулсан. 4. Аудитор, шинжээчдийн мэдлэгийг шалгах түвшин тогтоох шалгалтын материалыг боловсруулж, 11 аудитор, шинжээчдээс шалгалт авч, шалгалтын тайланг байгууллагын Даргын зөвлөлийн хуралд танилцуулан, цаашид шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж өгсөн. 	
<p>"2.0. Байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах” гэсэн зорилтын хүрээнд:</p>		

<p>2.1. <i>Нийслэлийн Дотоод аудитын албаны үйл ажиллагааны чадавхийг сайжруулах ажлын хүрээнд дотоод аудитын олон улсын сайн туршлагыг судлах</i></p> <p>2.1.1 Гадаад орнуудын дотоод аудитын хөгжил, хүрсэн түвшин, орчин үеийн чиг хандлагыг цахимаар судлах</p> <p>2.1.2 Дотоод аудит өндөр хөгжсөн орны туршлага судлах гадаад сургалт, арга хэмжээнд оролцох</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн Делойтт онч ХХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны чадавхийг сайжруулж, дотоод аудитын олон улсын сайн туршлагыг судалж, тэдний ноу-хаугаас суралцан, аудитын үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорилгоор Деллойт Онч ХХК-тай хамтран сургалт зохион байгуулахаар тус компанийн удирдлагуудтай ярилцаж байна. Мөн гадаад оронд болох сургалт, семинарт оролцох хүсэлтээ НЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэс, Төсөл, хамтын ажиллагааны хэлтэст удаа дараа тавиад байна.</p>	
<p>Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>		

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
<p>"1.0. Дотоод аудитын үйл ажиллагааг хангах" гэсэн зорилтын хүрээнд: 1.1.1. <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сэдвийн аудит хийж дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлэх</i></p> <p>1.1.1.1 <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үйл явц, үр дүн</i></p>	<p>А. Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2015 оны 2 дугаар сараас эхлэн сар бүр хянаж, нийслэл, 9 дүүргийн мэдээллийг нэгтгэн ажилласан.</p> <p>Б. 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан нийслэлийн Засаг даргын хамрах хүрээний байгууллагуудын нягтлан бодогч нарын семинарт Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон хагас жилийн үзлэг тооллоготой холбоотой танилцуулга хийсэн.</p> <p>В. Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны</p>	

	A/01 дүгээр захирамжаар байгуулсан “Нийслэлийн шилэн нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх, шилэн дансны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” ажлын хэсэгт тус хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, шинжээч Ц.Болдбаатар нар орж ажиллан, ажлын хэсгийн 6 удаагийн хуралд оролцон, шилэн дансны програм хангамжийг хийхэд саналаа бичгээр болон бусад хэлбэрээр өгсөн.	
1.2.2 Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтод тусгагдсаны дагуу Улаанбаатар хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд сэдвийн аудит хийж дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлэх 1.2.2.1 Улаанбаатар хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт	Энэхүү аудит нь тодорхой шалтгааны улмаас 2015 оны сүүлийн хагас жилд хийхээр хойшилсон бөгөөд уг аудитын удирдамжийг боловсруулж байна.	
Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО		

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i>	<i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i>	<i>Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Манлайллын зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i>
1	2	3
Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт-1: Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах, Зорилт-2: Ашиг сонирхлоос ангид байх а) Төрийн албан хаагчдын эрмэлзэх 9 зүйлийг мөрдлөг болгон ажиллах	а) “Төрийн албан хаагчийн эрмэлзэх 9 зүйл”-ийг мөрдлөг болгон хамт олноо манлайлан, үлгэр дуурайлалтай ажиллаж байна. б) Байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог нийт албан хаагчдаас авсан нууц санал хураалтын дүнг үндэслэн 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, нийт албан хаагчдад холбогдох ёс зүйн дүрмийг таниулан ажилласан. 2015 оны эхний хагас жилийн байдлаар албан	

<p>б) “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтны ёс зүйн дүрэм” болон мэргэжлийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах, в) Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж өгөх.</p>	<p>хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажилласнаар ёс зүйн зөрчлийн талаар гомдол гараагүй байна. в) Авлигын эсрэг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнан ажиллаж байна. Ажилтан, албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, аудитор, шинжээчдийн аудит эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг авч холбогдох хууль, журмын дагуу бүртгэн, тайлагнаж байна.</p>	
<p>2. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах, Зорилт-2: Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж ажиллах. а) Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, б) Ажилтан, албан хаагчдын холбогдох мэдээллийг цахим хуудсанд байрлуулж, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх, в) Ажлын байрны сул орон тоог цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх.</p>	<p>а) Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон жилийн төсөв, холбогдох хуулиар оруулах бусад мэдээллийг хуулийн хугацаанд shilendans.ub.gov.mn сайтад оруулан ажилласан. б) Байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, байршлийн мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2014 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн 2014 оны гүйцэтгэлийн мэдээ, 2014 оны авилгын эсрэг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийн ил, тод байдал, иргэдийн мэдээлэл хүлээн авах эрхийг хангаж ажиллах 2014 оны төлөвлөгөөний тайлан, цаг үеийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нийт 30 мэдээ нийтлэсэн. в) Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудсанд нийт 10 мэдээ нийтлэсэн. - Төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор: Байгууллагын 2015 оны төсөв, 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан, 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг</p>	

	байгууллагын цахим хуудсанд нийт 8 мэдээ нийтлэсэн.	
<p>3. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, хадгалалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах Зорилт-2: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах</p> <p>а) Байгууллагын төсвийн гүйцэтгэл, жилийн төсөв, төсвийн төслийг байгууллагын цахим хуудсанд байрлуулах, б) худалдан авах ажиллагаа, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудас, мэдээллийн самбарт мэдээлэх, в) Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд байршуулах.</p>	<p>а) Холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2015 оны төсөв, 2015 оны 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан зэрэг нийт 7 мэдээг байгууллагын цахим хуудсанд нийтлэсэн. б) Мөн байгууллагын 2015-2017 оны төсвийн дунд хугацааны төлөвлөгөөний төсөл, 2015 оны төсөв, санхүүгийн тайлан, 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд мэдээлсэн. в) Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг байгууллагын болон шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.</p>	
<p>4. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-1: Байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлд хяналт тавьж ажиллах</p> <p>а) Үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, б) Эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг цаг тухайд нь үнэн зөв явуулах, в) Байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулах.</p>	<p>а) Ажилтан, албан хаагчдыг ажиллах хэвийн нөхцөл бололцоогоор хангахын тулд 12 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 9148.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материалаар хангасан бөгөөд байгууллагын эд хөрөнгийг зөв зохистой, ариг гамтай ашиглах, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар холбогдох журмыг албан хаагчдад танилцуулсан. б) НДАА-ны даргын 2015.06.22-ны өдрийн А/07 дугаар тушаалаар 2015 оны хагас жилийн байгууллагын эд хөрөнгийн тооллогын комиссыг томилон тооллого хийсэн бөгөөд энэ оны эхний хагас жилийн байдлаар 35 нэр төрлийн 61,317,000.0 төгрөгийн үндсэн хөрөнгө, 40 нэр төрлийн 3,315,587.0 төгрөгийн бараа материал, нийт 64,632,587.0 төгрөгийн хөрөнгө тоолсон. в) Байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах зөвлөл холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.</p>	
<p>5. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар: Зорилт-1: Ажилтан, албан хаагчдын мэдлэг</p>	<p>а) Албан хаагчдын мэргэжлийн ур чадварын нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх дунд хугацааны “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр” боловсруулж</p>	

<p>боловсролыг сайжруулж, төрийн алба болон дотоод аудитаар мэргэшсэн чадвартай баг хамт олон бүрдүүлэх</p> <p>Зорилт-2: Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах</p> <p>а) Ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн болон мэргэшлийн сургалтанд хамруулах, суралцах үйл явцыг дэмжих,</p> <p>б) Төрийн жинхэнэ албан хаагчдад ажлын үр дүнгээр зэрэг дэв олгуулах, шатлал ахиулах,</p> <p>в) Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэх, дэмжлэг, тусламж үзүүлэх.</p>	<p>батлуулсан. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад бүх ажилтан, албан хаагчдыг хамруулсан. Дэлхийн банк, Сангийн яамнаас зохион байгуулсан Дотоод аудитын сургалтад дарга Д.Нацагдорж, Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Н.Наранчимэг нар оролцсон. Санхүүгийн аудитын хэлтсийн аудитор Д.Лувсанчимэдийг мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтад хамруулж байна. 7 албан хаагчийг мэргэжлийн англи хэлний сургалтад хамруулснаас гадна хүний нөөц, э-оффис, архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтуудад холбогдох албан хаагчид хамрагдсан. Энэтхэгийн ЗГ-ын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны “Нийгмийн хөгжлийн сургалтын хөтөлбөр”-т хамрагдахыг хүссэн, болзол шаардлагыг хангасан 8 албан хаагчдын материалыг хүргүүлсэн.</p> <p>б) 2015 онд 16 ажилтан, албан хаагчидтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж, эхний хагас жилийн байдлаар 15 албан хаагчийн ажлыг дүгнэж, 60 хувь нь А, 40 хувь нь В үнэлгээтэй дүгнэн, мөнгөн урамшуулал олгохоор, 8 албан хаагчийн албан тушаалын шатлалыг ахиулахаар шийдвэрлээд байна.</p> <p>Мөн Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан мэргэжлээрээ 5-аас дээш жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан 4 албан хаагчийг Сангийн яамны “Жуух бичиг”-ээр шагнуулахаар тодорхойлсон.</p> <p>в) 2015 онд ажилтан, албан хаагчдад нийт 121014.2 мянган төгрөгийн цалин, урамшуулал, 4113.2 мянган төгрөгийн тэтгэмж тусламж олгож, нийгмийн хамгааллын зардалд 13512.2 мянган төгрөг зарцуулсан.</p> <p>Мөн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарч, биеийн тамир, спортын хамтлагийг шинэчлэн байгуулж, ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх биеийн тамир, спортын тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион байгуулах</p>	
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

	<p>төлөвлөгөө гарган ажиллаж байна. Нийслэлд дотоод аудитын алба байгуулагдсаны нэг жилийн ойг тохиолдуулан боулингийн тэмцээн зохион байгуулж, усан спорт, сургалтын төвд хөнгөлттэй үнээр 6 албан хаагч суралцсан. 2015.05.22-нд Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Нийслэл, дүүргийн Дотоод аудитын албадын дунд Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын албанаас зохион байгуулсан “Дотоод аудит-2015” анхдугаар спорт тэмцээнд амжилттай оролцож, манай гар бөмбөгийн холимог баг 1-р байр эзэлсэн.</p> <p>Мөн хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ, мод тарих ажил, Сүхбаатар аймагт гарсан байгалийн гамшгийн хохирлыг арилгахад зориулж мөнгөн хандив цуглуулах зэрэг ажилд ажилтан, албан хаагчдыг зохион байгуулан оролцсон.</p> <p>Цаашид албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, цалингийн сүлжээний шатлалыг ахиулах, мэргэжил, боловсролыг нь дээшлүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг боломжит хэмжээгээр хангахаар төлөвлөж байна.</p>	
<p>Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>		